



БАТЛАВ
"ДЦС-4" ТӨХК-ийн ГҮЙЦЭТГЭХ

ЗАХИРАЛ *У.Сүхбаатар* ӨМӨРХУЯГ

БАТЛАВ
"ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС" ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ *А.Ганболд*



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХАЛУУН УС ХУДАЛДАХ ГЭРЭЭ

2021 он *01* дугаар сарын *15* ны өдөр

№ *3/2021-04* Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас "ДЦС-4" ТӨХК-г төлөөлж БҮЭД захирал Б.Сандуйжав /цаашид худалдагч гэх/ нөгөө талаас "ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС" ХХК-ийн ХАА-ны дарга Ц.Баасандорж /цаашид худалдан авагч гэх/ нар нь Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалтыг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг.Нийтлэг зүйл

1.1 Энэхүү гэрээний зорилго нь "ПРЕМИУМ БЬЮЛДИНГ МАТЕРИАЛС" ХХК-ийн хүсэлтийн дагуу үйлдвэрлэлийн зориулалттай 50-70⁰С-тай халуун усыг зөөврөөр тээвэрлэж авах нөхцлийг хангах ба тээврийн хэрэгслийг орж гарахад хяналт тавих усны төлбөрийг цаг хугацаанд нь гэрээнд заасны дагуу төлөх, гэрээт хугацаа эхлэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажсанаар гэрээ хууль зүйн хүчин төгөлдөр болж, худалдах худалдан авах ажиллагаа эхлэнэ.
- 2.2 Худалдах ба худалдан авах ажиллагаа нь 2021 оны 01-р сарын 13-наас 2021 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаатай явагдана.
- 2.3 Хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний гүйцэтгэлийн хугацааг сунгаж болно.

Гурав. Төлбөр тооцоо

- 3.1 Үйлдвэрлэлийн зориулалттай 1м3 халуун ус 5500 төгрөг байхаар талууд харилцан тохиролцов. Энэ үнэнд НӨАТ орсон болно.
- 3.2 Худалдан авагч нь дунджаар өдөрт 50-70 тонн халуун ус авна. Энэ нь тухайн өдрийн зуурмагийн захиалгын хэмжээнээс хамаарч хэлбэлзэж болно.
- 3.3 Усны үнийг урьдчилан "ДЦС-4" ТӨХК-ний дансанд шилжүүлсэн байна.

Худалдагч :

Худалдан авагч:

Finance Department
Signature: *Б.Мөнх*
date: 2021.01.15

Дөрөв. Худалдан авагчийн үүрэг

- 4.1 Худалдан авагч нь ДЦС-4 ТӨХК-нд дараахь дугаартай тээврийн хэрэгсэлийг нэвтрүүлнэ.

Үүнд: 89-56УАЕ, 89-56УАВ, 89-56УАН, 53-71УАМ, 53-81УАМ.
Тээврийн хэрэгсэлийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллана.
Замын хөдөлгөөний дүрмийг чанд сахиж ажиллана.

- 4.2 Худалдан авагч Захиргааны 2-р байрны хашаан дотор ахуйн байр №-4-ийн ар талын дренажаас халуун усыг авахаар орохдоо харуулаар дамжуулан ээлжийн инженерээс зөвшөөрөл авч, тухайн ээлжийн сантехникийн болон фекалын жижүүрийн аль нэгээр хаалтыг онгойлгуулж авна. Хаалтыг өөрсдөө дур мэдэн онгойлгохыг хориглоно.
- 4.3 Худалдан авагч нь зааж өгсөн газраас ус авахдаа шлангийн усыг юүлж, хөлдөхөөс сэргийлж ажиллахаас гадна орчиндоо ус асгаж мөс тогтоохгүй байна. Мөс тогтсон тохиолдолд өөрсдөө цэвэрлэж цаг тухай бүрд нь цэвэрлэнэ.

Тав. Худалдагчийн үүрэг

- 5.1 Худалдагч нь худалдан авагч талын харуулаар орох гарахад хяналт тавьж халуун ус авах нөхцлийг хангаж ажиллана.
- 5.2 Станцын ээлжийн инженер Захиргааны 2-р байрны хашаан дотор ахуйн байр №-4-ийн ар талын дренажаас халуун усыг авахаар орохдоо харуулаар дамжуулан ээлжийн инженерээс зөвшөөрөл авч, тухайн ээлжийн сантехникийн болон фекалын жижүүрийн аль нэгээр хаалтыг онгойлгуулж авна.
- 5.3 Хаалтыг өөрсдөө дур мэдэн онгойлгохыг хориглоно.

Зургаа. Хоёр талын эрх

- 6.1 Гэрээнд заасны дагуу худалдан авах ажиллагаанд ДЦС-4 ТӨХК-аас борлуулалтын мэргэжилтэн худалдан авагч талаас хангамжийн менежер нь хянаж баталгаажуулж байна.
- 6.2 Гэрээнд зааснаас өөр үйлдэл хийх буюу эд зүйлийг эвдсэн, хулгайлсан, архи уусан зэрэг бусад хэв журмын зөрчил гаргасан тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй.
- 6.3 Техник Хяналтын Хэлтсийн шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, эсэргүүцсэн тохиолдолд гэрээг цуцлуулах хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Худалдагч :

Худалдан авагч:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Худалдагч талыг төлөөлж

Худалдан авагч талыг төлөөлж:

ДЦС-4" ТӨХК-ИЙН ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ
БӨГӨӨД ЕРӨНХЛЭГЧИЙН ИНЖЕНЕР

..... Б.ГАНХУЯГ
/2021 ОН 11 САР 15 ӨДӨР/

БҮЭД ЗАХИРАЛ

..... Б.САНДУЙЖАВ

/2021 ОН 11 САР 15 ӨДӨР/

"ДЦС-4" ТӨХК-ИЙН

БМА-НЫ ДАРГА

..... С.АЛТАНХУЯГ

/2021 ОН 11 САРЫН 15 ӨДӨР/

"ДЦС-4" ТӨХК-НИЙ

СБХ-ИЙН ДАРГА

..... Д.ТӨМӨРТӨГӨӨ

/2021 ОН 11 САРЫН 15 ӨДӨР/

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

..... Ч.БЯМБАСҮРЭН

/2021 ОН 11 САРЫН 15 ӨДӨР/

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

..... С.ДОНИД

/2021 ОН 11 САРЫН 15 ӨДӨР/

"ПРЕМИУМ БЬЮЛДИНГ
МАТЕРИАЛС" ХХК- ИЙН ХАА-НЫ ДАРГА

Ц.БААСАНДОРЖ

2021 ОН 11 САРЫН 15 ӨДӨР

ХОЁР ТАЛЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ

Монгол улс,
16100 Улаанбаатар хот
Баянгол дүүрэг, 20 дугаар хороо
"ДЦС-4" ТӨХК
Утас: 70170783
ДАНС: ХААН БАНК 5038008126

Худалдан авагчийн хууль ёсны хаяг, утас,
факс:

БГД 20-р хороо эрчим хүчний гудамж

РД: 6266258 Утас: 7777-3311; 8888-6015

Худалдагч :

Худалдан авагч: